

ЕБС-ИЙН СУРАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/Сургуулийн номын санчаас 10-12 дүгээр ангийн сурагчдад зориулсан сургалтын модуль/

Р.Туяа Ph.D

/БМДИ-ийн албаны дарга/ tuya@itpd.mn

Модулийн зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн номын санчид 2014 онд батлагдсан Номын сангийн тухай хууль, БСШУ-ны сайдын 2008 оны 10 сарын 21-ны 30 тоот “ЕБС-ийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм” тушаал, Стандарт хэмжил зүйн газраас баталсан “Номын сангийн орчны нөхцөл үйл ажиллагаанд тавигдах шаардлага” MNS 5742:2007 стандартыг хэрэгжүүлж ажиллахдаа ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга аргачлал эзэмшүүлэхэд оршино.

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж: ЕБС-ийн номын санч та энэхүү модулийг хэрэгжүүлэхдээ дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном, багшийн гарын авлага, сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж тус бүртэй нарийвчлан танилцаж судалсан байх
- Өөрийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт болон холбогдох тушаал шийдвэрт заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ахлах ангийн сурагчдад багшийн заасан хичээлийг хичээлийн бус цагаар давтах, бие даан суралцах, сурагч өөртөө мэдлэг бүтээхэд туслах, чиглүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгод нийцүүлэн ажлаа төлөвлөх
- Ажил мэргэжлийн талаарх мэдээлэл цуглуулах, эх сурвалжууд, цуглуулсан мэдээллээ хэвлэж олшруулах, суралцагчдад ээлтэй байдлаар хэвлэмэл материал, хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжоор хангах
- Сурагчдад өөрийн хэрэгцээтэй ном гарын авлага хэрэглэгдэхүүнийг оновчтой ашиглах, номын сангийн каталоги ашиглах, хайлт хийхэд дэмжлэг үзүүлэх
- Ахлах ангийн сурагчдад номын ангилал, шифр унших, ном, хэвлэлийн бүтээгдэхүүний төрөл, ангилал, номын сангийн мэдээллийн нөөцийг үр дүнтэй ашиглах чадварт суралцахад дэмжлэг үзүүлэх
- Цаг хугацааны үнэ цэнэ, цагийн менежментийн талаар танхимын бус сургалт үйл ажиллагаа зохион байгуулах
- Сурагчдад номыг зорилготой унших, хурдтай унших техникт суралцахад тодорхой мэдээлэл дэмжлэг үзүүлэх
- Ахлах ангийн сурагчдад өөрийгөө илэрхийлэх эсээ, илтгэл бичих, бие даалт хийх, дадлага туршлагад суралцахад зориулан мэдээллээр хангах
- Сургуулийн номын санд ном зүйн бүртгэлүүд ашиглах, ишлэл зүүлт хийх, ном зүй бичих, толь бичиг, лавлах материал ашиглах арга зүйд суралцахад дэмжлэг үзүүлэх

- Сурагчдад интернет орчинд ажиллах хайлт хийх, цахим ном, хичээл, онлайн сан ашиглахад тусламж үзүүлж зөвлөн туслах
- Сурагчдад ажил мэргэжлийн судалгаа хийх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангахад туслах
- Номын сангаа уншигчдын ая тухтай байдлыг хангахуйц номын сангийн орчин нөхцөл, техник технологи бүрдүүлсэн байх
- Номын сангаар үйлчлүүлэгчидтэй эелдэг харилцаж, ёс зүйтэй байх
- Сургуулийн номын сангаас сурагчдын ялгаатай байдалд тохируулан дараах үйлчилгээний хэлбэрүүдийг ашиглах. Үүнд:
 - Уншлагын танхимаар
 - Гэрээр ном олгох
 - Ном солилцоогоор
 - Салбар номын сан
 - Нүүдлийн номын сан
 - Зөөврийн номын сан
- Сурагчид номын сангаар үйлчлүүлэх боломжит цагаар ажиллах
- Шинээр номын баяжилт хийхдээ тодорхой хувь хэмжээг ажил мэргэжлийн холбогдолтой ном гарын авлагаар хангах
- Шинээр ирсэн ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой ном гарын авлагыг нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулах
- Сургуулийн нөөц боломжид тулгуурлан “ажил мэргэжлийн чиг баримжааны булан” байгуулах (сонголттой)
- Сургуулийн төвшинд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ном гарын авлагаар хангахад мэргэжлийн байгууллага болон ТББ-тай хамтран ажиллах
- Сургуулийн номын санч, сургуулийн удирдлага интернетийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, оператортай интернетээс ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой эх сурвалж, материал цуглуулах, сургуулийн номын санд байршуулах талаар харилцан тохиролцох
- Ажил мэргэжлийн чиглэлээр гарсан хуучин ном сурах бичгийг сэлбэн ашиглах боломжоор хангах
- Ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн ном гарын авлага танилцуулах үйл ажиллагааг нийтээр, хэсэгчилсэн, ганцаарчилсан байдлаар зохион байгуулах
- Сургуулийн номын санд байгуулсан ажил мэргэжлийн төвөөс мэдээллийг тогтсон цагт авахаар зохион байгуулах
- Багш, сурагчдаас ажил мэргэжлийн чиглэлээр ном хэрэглэгдэхүүний хэрэгцээний судалгаа авах
- Сургуулийн вебсайтад ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой функц нэмж оруулах
- Ахлах ангийн эцэг эхчүүдтэй хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил сурталчлах ажлыг сургуулийн хэмжээнд нэгдсэн байдлаар анги удирдсан багш нартай хамтран зохион байгуулах
- Сурагчдын дунд мэргэжлийн багш нартай хамтран ажил мэргэжлийн чиглэлээр эсээ, уралдаан зохион байгуулж, илтгэл судалгааны ажил өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Ажил мэргэжлийн чиглэлээр сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбар ажиллуулах
- Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгөх ажил зохион байгуулах
- Сургуулийн номын санч бусад номын сантай ажил мэргэжлийн чиглэлээр гарсан номын солилцоо хийх

Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн загвар:

Сургуулийн номын санч та өөрийн сургуулийн алсын хараа, эрхэм зорилго болон тухайн хичээлийн жилийн зорилго, зорилтод нийцүүлэн өөрийн ажлыг төлөвлөн боловсруулдаг. Номын сангаас зохион байгуулах энэ ажлын төлөвлөгөөндөө ахлах ангийн сурагчдыг ажил мэргэжлээ сонгоход зориулсан ном, сурах бичиг, сонин, сэтгүүл, хэвлэмэл бус баримт, материал болон цаг үеийн холбогдолтой мэдээллээр тасралтгүй хангах, тэдэнд сурч боловсрох, хөгжих, чөлөөт цагаа өнгөрүүлэх, бие хүн болон төлөвшихөд нь номоор дамжуулан туслах, оюуны хөрөнгө оруулалт хийх үндсэн чиг үүрэг хүлээх шаардлагатай. Иймд ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд номын санчийн зүгээс үзүүлэх дэмжлэг бүхий ажлыг 10-12 дугаар ангийн сурагчдын дунд нэгдсэн байдлаар зохион байгуулах жишээ хөтөлбөрийн загварыг тусгалаа.

“Ажил мэргэжлийн ном, сурах бичгийг танилцуулах” өдөрлөгийн хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго: сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, анги удирдсан багш нарт АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном, багшийн гарын авлагыг танилцуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

Зорилтот бүлэг:сургуулийн 10-12 ангийн анги удирдсан 6 багш, 108 сурагч

Зохион байгуулагч: сургуулийн номын санч, нийгмийн ажилтан

Хугацаа: 2021 оны 09 сарын 28 14-17 цаг

Хүлээгдэж буй үр дүн: Ахлах ангийн багш сурагчдад сургуулийн номын санд байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ном гарын авлага, сурах бичгийг хэрэгжүүлэх мэдлэг мэдээлэлтэй болсон байна.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын нөөц	Хүрсэн үр дүн
1	Ажил мэргэжлийн чиглэлээр сургуулийн номын санд байгаа ном сурах бичгийн үзэсгэлэнтэй танилцах	14.00-15.00	Ном, гарын авлага сурах бичиг, цахим мэдээлэл хаяг	
2	Зохиогч болон төсөл хөтөлбөрийн хүрээнд гарсан сурах бичгийн боловсруулалт хийсэн хүнтэй уулзалт хийх	15.00-16.00	Зохиогч, үндэсний сургагч багш, төслийн ажилтан	
3	Ном гарын авлага сурах бичгийг хэрэглэх арга аргачлалтай танилцах, дасгал хийх	16.00-16.30	Сургалтын хэрэглэгдэхүүн	
4	Санал асуулга, ярилцлага	16.30-17.00		

Хөтөлбөр боловсруулсан /...сургуулийн номын санч /

Хөтөлбөртэй танилцсан:/ нийгмийн ажилтан /

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлээр ахлах ангийн сурагчдын эзэмшсэн мэдлэг чадварт дэмжлэг үзүүлэх: Сургуулийн номын санч та ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ахлах ангийн суралцагчийн гарын авлагаар сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмшиж байгааг судлан танхимын болон танхимын бус аргаар ахлах ангийн сурагч, анги удирдсан багш, эцэг эх, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлагуудтай хамтран сурагчдад хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар энэ хэсэгт дурдах болно.

10 дугаар анги: / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

Зорилго:

- Сурагчид 9 дүгээр ангид хийсэн сонголтоо эргэн харах, дүгнэх
- Ажил мэргэжлийн талаар илүү бодитой ойлголттой болох
- Ирээдүйгээ төсөөлөх
- Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлах
- 11 дүгээр ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох

10 дугаар ангийн сурагчид ажил мэргэжлийн чиг баримжааны талаар дараах чадамжтай болоход номын санч та яаж дэмжлэг үзүүлэх вэ?

№	Сурагчдын эзэмших чадамж	Номын санчийн зүгээс үзүүлэх дэмжлэг
1	Өөрийгөө ойлгох	Цагийн менежментийн сургалт үйл ажиллагаа зохион байгуулах Сурагчдад номыг зорилготой уншихад дэмжлэг үзүүлэх Ахлах ангийн сурагчдад өөрийгөө илэрхийлэх эсээ, илтгэл бичих, суралцахад зориулан мэдээллээр хангах Сурагчдад ажил мэргэжлийн судалгаа хийх боломжоор хангах Номын сангийн үйлчилгээг уншлагын танхимаар, гэрээр ном олгох аргаар зохион байгуулах Ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн ном гарын авлага танилцуулах үйл ажиллагааг ганцаарчилсан байдлаар зохион байгуулах Багш, сурагчдаас ажил мэргэжлийн чиглэлээр ном хэрэглэгдэхүүний хэрэгцээний судалгаа авах
2	Ажил мэргэжлийн талаар ойлгох	10 дугаар ангийн сурагчийн гарын авлагатай танилцаж дасгал хийх Ажил мэргэжлийн чиглэлээр сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбартай танилцан мэдээлэл авах Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд

		сургуулийн ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгөх ажил зохион байгуулах Сургуулийн номын санд ном зүйн бүртгэлүүд ашиглах, толь бичиг, лавлах материал ашиглах арга зүйд суралцахад дэмжлэг үзүүлэх Сурагчдад интернет орчинд ажиллах хайлт хийхэд, тусламж үзүүлж зөвлөн туслах
3	Ажил мэргэжлийн зорилго дэвшүүлэх	Сурагчдад өөрийн хэрэгцээтэй ном гарын авлага хэрэглэгдэхүүнийг оновчтой ашиглахад дэмжлэг үзүүлэх Сургуулийн вебсайтад ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой функц нэмж оруулан мэдээллээр хангах Өөрийн сонгосон мэргэжлээр судлах хичээлийг тодорхой болгоход дэмжлэг үзүүлэх Өөрийн сайн суралцдаг судлагдахуунаар ямар мэргэжил эзэмших боломжтой талаар судлахад дэмжлэг үзүүлэх
4	Дүгнэх сонгосон ажил мэргэжлээ эргэн харах	10 дугаар ангийн эцэг эхчүүдэд анги удирдсан багштай хамтран ажил мэргэжлийн талаар сургалт зохион байгуулах Сурагчдын сонгосон мэргэжил эцэг эхийн сонголт хоорондын зөрүүтэй байдалд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх

11 дугаар анги: / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

Зорилго:

- Сурагчид 10 дугаар ангид хийсэн төлөвлөгөөгөө эргэн харах, дүгнэх
- Дээд боловсрол, мэргэжлийн боловсролын хөдөлмөрийн зах зээлийн талаарх ойлголттой болох
- Ажил мэргэжлийн сонголт ижил төстэй шинжүүдтэй танилцах
- Ажил мэргэжлийн талаарх шийдвэр гаргах
- Их дээд сургуульд элсэх талаар сонголт хийх шийдвэр гаргах

11 дүгээр ангийн сурагчид ажил мэргэжлийн чиг баримжааны талаар дараах чадамжтай болоход номын санч та яаж дэмжлэг үзүүлэх вэ?

№	Сурагчдын эзэмших чадамж	Номын санчийн зүгээс үзүүлэх дэмжлэг
		Цаг хугацааны үнэ цэнэ, цагийн менежментийн талаар танхимын бус сургалт үйл ажиллагаа зохион байгуулах Сурагчдад номыг зорилготой унших, техникт суралцахад тодорхой мэдээлэл дэмжлэг үзүүлэх Ахлах ангийн сурагчдад өөрийгөө илэрхийлэх эсээ, илтгэл бичих, бие даалт хийх, суралцахад зориулан мэдээллээр хангах

1	Өөрийгөө ойлгох	Сурагчдад ажил мэргэжлийн судалгаа хийх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангахад туслах Номын сангаас сурагчдад ном солилцоогоор салбар номын сангаар үйлчлүүлэх боломжоор хангах Ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн ном гарын авлага танилцуулах үйл ажиллагааг хэсэгчилсэн, ганцаарчилсан байдлаар зохион байгуулах Багш, сурагчдаас ажил мэргэжлийн чиглэлээр ном хэрэглэгдэхүүний хэрэгцээний судалгаа авах
2	Ажил мэргэжлийн талаар ойлгох	11 дүгээр ангийн сурагчийн гарын авлагатай танилцаж дасгал хийх Ажил мэргэжлийн чиглэлээр сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбар ажиллуулах Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгөх ажил зохион байгуулах Сургуулийн номын санд ном зүйн бүртгэлүүд ашиглах, арга зүйд суралцахад дэмжлэг үзүүлэх Сурагчдад интернет орчинд ажиллах хайлт хийх, цахим ном, онлайн сан ашиглахад тусламж үзүүлж зөвлөн туслах
3	Нөлөөллийг ойлгох	Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход нөлөөлж буй нөхцөл байдлын судалгааг нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах Судалгаанд үндэслэн тухайн мэргэжлийн төгсөгч болон уулзалт зохион байгуулах Ахлах ангийн сурагчдыг ажлын байрны сургалтад хамруулахад мэдлэг мэдээллээр хангах Өөрийн сургуулийн төгсөгчидтэй уулзалт зохион байгуулах нөлөөллийн ажил зохион байгуулах
4	Шийдвэр гаргах	Ахлах ангийн сурагчид сонгосон хичээлээр ажил мэргэжлээ сонгох шийдвэр гаргахад анги удирдсан багштай хамтран ажиллах мэдээллээр хангах

12 дугаар анги: / Ажил мэргэжлийн чиг баримжаа ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном /

Зорилго:

- Сурагчид 11 дугаар ангид хийсэн төлөвлөгөөгөө эргэн харах, сайжруулах
- Дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургуульд өргөдөл гаргах
- Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх
- Тодорхойгүй нөхцөл байдалд шийдвэр гаргах

12 дугаар ангийн сурагчид ажил мэргэжлийн чиг баримжааны талаар дараах чадамжтай болоход номын санч та яаж дэмжлэг үзүүлэх вэ?

№	Сурагчдын эзэмших чадамж	Номын санчийн зүгээс үзүүлэх дэмжлэг
---	--------------------------	--------------------------------------

1	Өөрийгөө ойлгох	<p>Цаг хугацааны үнэ цэнэ, цагийн менежментийн талаар танхимын бус сургалт үйл ажиллагаа зохион байгуулах</p> <p>Сурагчдад номыг зорилготой унших, хурдтай унших техникт суралцахад тодорхой мэдээлэл дэмжлэг үзүүлэх</p> <p>Ахлах ангийн сурагчдад өөрийгөө илэрхийлэх эсээ, илтгэл бичих, бие даалт хийх, дадлага туршлагад суралцахад зориулан мэдээллээр хангах</p> <p>Сурагчдад ажил мэргэжлийн судалгаа хийх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангахад туслах</p> <p>Номын сангаас сурагчдад ном солилцоогоор салбар номын сангаар үйлчлүүлэх боломжоор хангах</p> <p>Ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн ном гарын авлага танилцуулах үйл ажиллагааг нийтээр, хэсэгчилсэн, ганцаарчилсан байдлаар зохион байгуулах</p> <p>Багш, сурагчдаас ажил мэргэжлийн чиглэлээр ном хэрэглэгдэхүүний хэрэгцээний судалгаа авах</p>
2	Ажил мэргэжлийн талаар ойлгох	<p>12 дугаар ангийн сурагчийн гарын авлагатай танилцаж дасгал хийх</p> <p>Ажил мэргэжлийн чиглэлээр сургууль дээр тусгайлсан мэдээллийн самбар ажиллуулах</p> <p>Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн ажил мэргэжлийн талаар мэдээлэл өгөх ажил зохион байгуулах</p> <p>Сургуулийн номын санд ном зүйн бүртгэлүүд ашиглах, толь бичиг, лавлах материал ашиглах арга зүйд суралцахад дэмжлэг үзүүлэх</p> <p>Сурагчдад интернет орчинд ажиллах хайлт хийх, цахим ном, ажил мэргэжлийн хичээл, онлайн сан ашиглахад тусламж үзүүлж зөвлөн туслах</p>
3	Нөлөөллийг ойлгох	<p>Сургуулийн ажил мэргэжлийн талаарх судалгаанд үндэслэн</p> <ul style="list-style-type: none"> • Төгсөгч нартай уулзалт хийх • Эцэг эхтэй уулзалт хийх • Ажлын байранд зочлох • Алдартай хүнтэй уулзалт хийх • Судалгаа хийж хэлэлцүүлэг хийх
4	Ажил мэргэжлийн зорилго дэвшүүлэх	<p>Сурагчдад ажил мэргэжлийн талаарх өөрийн хэрэгцээтэй ном гарын авлага хэрэглэгдэхүүнийг оновчтой ашиглахад дэмжлэг үзүүлэх</p> <p>Сургуулийн вебсайтад ажил мэргэжлийн чиг баримжаатай холбоотой функц нэмж оруулан мэдээллээр хангах</p> <p>Судалсан судлагдахуунаар сонгох ажил мэргэжлээ тодорхой болгоход мэдээллээр хангах</p>

5	Шийдвэр гаргах	Мэргэжлийн сургуулиудын талаарх мэдлэг мэдээлэл олгож шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх Тухайн мэргэжлийг эзэмшсэнээр ажлын байрны талаарх мэдлэг мэдээллээр хангах Сурагчдад сонгосон мэргэжлээрээ суралцах талаар эцэг эхтэйгээ зөвшилцөх, ойлгуулах мэргэжлийн талаар мэдээлэл өгөхөд дэмжлэг үзүүлэх
6	Хэрэгжүүлэх /үйл хэрэг болгох/	Сонгосон мэргэжлийн талаарх мэдлэг мэдээллээр хангахад сурагчдад дэмжлэг үзүүлэх Сонгосон мэргэжлийн судлагдахууныг дэмжсэн ном гарын авлагаар хангахад дэмжлэг үзүүлэх
7	Дүгнэх /эргэн харж сайжруулах/	12 дугаар ангийн эцэг эхчүүдэд анги удирдсан багштай хамтран ажил мэргэжлийн талаар сургалт зохион байгуулах Мэргэжлийн сургуулийн сурталчилгаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

Модуль хэрэгжүүлэх арга зүй: Сургуулийн номын санч та ахлах ангийн сурагчид ажил мэргэжлийн талаар ямар мэдлэг ойлголттой байгаа түүнд яаж дэмжлэг үзүүлэх талаар тодорхой мэдээлэлтэй боллоо. Харин энэ хэсэгт дээрх дэмжлэг болох ажлаа ямар арга зүйгээр зохион байгуулах боломжтой талаар мэдээлэл хүргэх гэж байна. Энэ нь 10-12 анги тус бүрдээ тухайн насны хүүхдийн зорилго, насны онцлогоос хамааран зохион байгуулж буй ажил нь ялгаатай байх боломжтой. Мөн тодорхой нэг ажлыг 10-12 ангийн сурагчдад өөр өөр арга зүйгээр оролцоонд тулгуурлан зохион байгуулах боломжтой. Иймд анги тус бүр дээр ямар арга зүй хэрэглэх талаар дараах хүснэгтэд загвар гарган хүргэж байна.

10 дугаар анги	11 дүгээр анги	12 дугаар анги
<ul style="list-style-type: none"> ▪ Багаар ажиллах ▪ Судалгаа шинжилгээ хийх ▪ Инсертийн арга ▪ Ярилцлага арга ▪ Харьцуулан дүгнэх ▪ Дүрд тоглох арга ▪ Төсөөлөх арга ▪ Анги бүлгээр зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> ▪ Багаар ажиллах ▪ Судалгаа шинжилгээ хийх ▪ KWL арга ▪ Өөрийгөө илэрхийлэх ▪ Жишээнд суралцах ▪ Задлан шинжлэх ▪ Уншигчдын семинар хийх ▪ Хэсэгчилсэн зөвлөгөө өгөх 	<ul style="list-style-type: none"> ▪ Багаар ажиллах ▪ Судалгаа шинжилгээ хийх ▪ Хамтран суралцах арга ▪ Бүлэглэх арга ▪ Илтгэх урлаг ▪ Газар орноо судлах ▪ Бүтээлийн сан ажиллуулах ▪ Ганцаарчилсан зөвлөгөө өгөх

Сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа зохион байгуулагдсаны үр дүн: Сургуулийн номын санч та өөрийн сургуулийн ахлах ангийн сурагчдад багш, эцэг эх, сургуулийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүн нь дараах байдлаар харагдана. Үүнд:

- Танай сургуулийг тухайн хичээлийн жилд төгссөн сурагчид мэргэжлийн сургуульд элсэн орсон үзүүлэлтэд ахиц гарсан.
- Танай сургууль төгссөн сурагчдын мэргэжилтэй ажилтан болсон тоон үзүүлэлтэд ахиц гарсан байна.

- Сургуулийн номын санд ажил мэргэжлийн талаарх ном гарын авлага тодорхой хувийг эзэлнэ.
- Ахлах ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр ямар мэргэжил эзэмших талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Ахлах ангид хичээл орж байгаа багш нар өөрийн хичээлээр эзэмших мэргэжлийг аль их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуульд эзэмшиж болох талаарх мэдлэг ойлголтод ахиц гарсан байна.
- Сургуулийн номын сан болон цахим хуудсанд ажил мэргэжлийн талаарх мэдээлэл тогтмол гардаг болсон байна.
- Ахлах ангид хичээл зааж буй багш нарын заах аргад ахиц гарсан байна.
- Ахлах ангийн сурагчид өөрийн зорилготой болж бие даах чадварт ахиц гарсан байна.
- Ахлах ангийн сурагчдын хичээлд оролцох оролцоо сургалтын чанарт ахиц гарсан байна.

Модуль боловсруулахад болон хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, ном зүй:

Гарын авлага: АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

Цахим эх сурвалж:

- www.mergejil.mn
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- www.onisep.fr
- www.myworldofwork.co.uk
- www.careers.govt.nz
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай

боловсрол"-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ